

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ...дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

**УЛСЫН ТЭМДЭГГИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

1/5 дугаар зүйлийн 5.1.46 дахь заалт:

“5.1.46.Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7.3-д заасан тусгай зөвшөөрөл олгох;”

2/21 дүгээр зүйлийн 21.1.36 дахь заалт:

“21.1.36.гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл олгоход 1 000 000-1 500 000 төгрөг.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ...дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн "...хуулийн" гэсний дараа "4.1.8-д заасан гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа," гэж, 11.5.1 дэх заалтын "...арилгах" гэсний дараа ", эрсдэлийг бууруулах" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ...дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

ОНЦ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Онц байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “тохиолдолд” гэсний дараа “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжөөр” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Онц байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “аюулт үзэгдэл, осол” гэснийг “гамшгийн онцгой нөхцөл байдал” гэж, 9 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийн “иргэний хамгаалалтын асуудал эрхэлсэн төв” гэснийг “Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэж, 12 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “нутгийн захиргааны” гэснийг “төрийн болон нутгийн захиргааны, онцгой байдал, дотоодын цэргийн” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ...дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР
БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсгийн “тоног төхөөрөмж,” гэсний дараа “багаж хэрэгсэл, техник,” гэж, 34 дүгээр зүйлийн 34.1.5 дахь заалтын “гэнэтийн” гэсний өмнө “гамшгийн онцгой нөхцөл байдал зарласан, гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн” гэж, 45 дугаар зүйлийн 45.7 дахь хэсгийн “хил хамгаалах” гэсний дараа “, онцгой байдлын” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ...дугаар
сарын ...ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
/шинэчилсэн найруулга/
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй.

1/5.13 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“5.гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрийг зөрчсөн, хөлбөгдөх нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар олон нийтийг төөрөгдүүлэх мэдээ, мэдээлэл түгээсэн, худал, хуурамч дуудлага өгсөн, зохиомол үнийн хөөрөгдөл үүсгэсэн, эсхүл эрх бүхий байгууллагаас төгтоосон хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалтын дэглэмийг зөрчсөн хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр төргөнө.”

2 дугаар зүйл. Зөрчлийн тухай хуулийн 4.3 дугаар зүйлийн “хохирол,” гэсний дараа “зардал,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Зөрчлийн тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/5.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал, аюулт үзэгдэл, осол, аюулын талаар олон нийтийг төөрөгдүүлэх мэдээ, мэдээлэл түгээсэн хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр төргөнө.”

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг